



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/11

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Үндсэн хөрөнгө акталж данснаас
хасах тухай**

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 дахь заалтууд, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 163 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 20 нэр төрлийн 30 ширхэг 5,737,290 (Таван сая долоон зуун гучин долоон мянга хоёр зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий үлдэх өртөггүй хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас хассугай.

2. 20 нэр төрлийн 30 ширхэг 5737290 (Таван сая долоон зуун гучин долоон мянга хоёр зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий үлдэх өртөггүй хөрөнгийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр), нярав (Н.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

СОТГОНБАЯР

